



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2016 оны 08 сарын 15 өдөр

Дугаар 46

Алтай

Ажил эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь

1. Аймаг орон нутагт сахилга, дэг журам, цаг үеийн ажлыг эрчимжүүлэх зорилгоор аймгийн Засаг дарга С.Гансэлэмд ДААЛГАХ нь:

1. 2016-2017 оны хот суурингийн болон мал аж ахуйн өвөлжөөлөлтийн бэлтгэл хангуулах зорилгоор аймгийн ЗДТГ-ын хэлтсүүд, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээн дэх хэрэгжүүлэх агентлагуудын болон төсөвт байгууллагуудын дарга нарын ээлжийн амралтыг түр зогсоож ажилд нь оруулах

2. Намрын ургац хураах, хадлан тэжээл бэлтгэх ажлыг зохион байгуулж эрчимжүүлж, өвөлжөөлөлтийн бэлтгэл ажлыг хангах

3. Төрийн /төсөвт байгууллагуудын/ болон төрийн өмчит аж ахуйн нэгжийн байгууллагын дарга эрхлэгч, төрийн албан хаагчдыг гадаад, дотоодод албан томилолтоор ажиллах асуудлыг хойшлуулах

4. Төсвийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж, үр ашиггүй зардал гаргахгүй ажиллах

2. Хамт олныг зохион байгуулалтайгаар амралтанд амраах, аялуулах зэрэг нэгдсэн арга хэмжээ зохион байгуулахгүй байх, нийт албан газар байгууллагууд төрийн албан хаагчдыг төрийн байгууллагын нэрээр төсөл хөтөлбөрийн сургалтад хамруулах асуудлыг хойшлуулж, төсвийн хийдэгдэл гаргахгүй ажиллахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээн дэх хэрэгжүүлэх агентлагуудын болон төсөвт байгууллага, төрийн өмчит аж ахуйн нэгжийн дарга нарт үүрэг болгосугай.

ДАРГА

Т.ГАНЗОРИГ

